



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.25 № 424
танай _____-ы № _____-т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ГУРВАНБАЯН
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Ж.ЭНХХУЯГ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Гурванбаян тосгоны захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг 2 албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт ²⁵... хуудастай.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж.ГАНБААТАР



232530425

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/011/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.4.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага.....	13
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	13
3.5.5 Үндсэн хөрөнгө	14
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:	20
5.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:.....	21
5.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:	21
5.3.1 Төлбөрийн акт	22
5.3.2 Албан шаардлага	22
5.3.3 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.25 № 407

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГУРВАНБАЯН
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ Ж.ЭНХХУЯГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн төсвөөс 728,821.7 мянган төгрөгийн дэмжлэг авч, 228,892.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 929,289.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ерөнхий орлогын дансанд 43,879.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 979,149.0 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрч 560,034.3 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 2,080.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 417,034.5 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232520407

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4 “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/ тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн бүрдлийг бүрэн хангаж ирүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		234,289.90	410,138.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	111,469.90	160,398.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	39,127.70	41,533.90
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	695.80	113,827.50
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	82,996.60	94,377.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,160,916.00	933,956.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,160,916.00	933,956.50
39200	Биет хөрөнгө		1,138,624.00	911,664.50
39300	Биет бус хөрөнгө	13	22,292.00	22,292.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,395,205.90	1,344,094.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		143.90	143.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	143.90	143.90
41300	Өглөг	17а, 17б	143.90	143.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,395,062.00	1,343,950.60
51	Засгийн газрын хувь оролцоо		1,395,062.00	1,343,950.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		165,881.10	165,881.10
51200	Хуримтлагдсан үр дүн		1,057,296.70	1,006,185.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		171,884.20	171,884.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,395,205.90	1,344,094.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,305,736.60	1,062,164.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО		175,316.50	225,233.70
110	Орлогын албан татвар		129,516.70	170,991.50
1100	Хувь хүний орлогын албан татвар		129,516.70	170,991.50
113	Хөрөнгийн албан татвар		19,492.10	17,710.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж		26,307.70	36,531.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	65,413.60	27,619.00
120	Нийтлэг татварын бус орлого		65,413.60	27,619.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,065,006.40	809,311.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,286,686.00	1,108,731.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,286,686.00	1,108,731.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		665,681.20	1,080,904.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		190,843.70	360,323.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		23,423.60	43,943.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		37,121.50	296,162.90
2104	Хангамж, бараа материалын зардал		39,928.40	40,203.60
2105	Нормативт зардал		136.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,854.00	27,730.70
2107	Томилолт, зочны зардал		7,448.00	12,228.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		229,491.50	8,085.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		125,434.60	292,226.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		621,004.80	27,827.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		19,050.50	(46,566.90)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		64,976.60	4,544.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(45,926.10)	(51,111.40)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,440,988.10	1,440,988.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,440,988.10	1,440,988.10
9	Тайлант үеийн үр дүн	(45,926.10)	(45,926.10)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,395,062.00	1,395,062.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,395,062.00	1,395,062.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,395,062.00	1,395,062.00
19	Тайлант үеийн үр дүн	(51,111.40)	(51,111.40)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,343,950.60	1,343,950.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,251,392.40	1,038,204.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	175,316.50	225,233.70
110	Орлогын албан татвар	129,516.70	170,991.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	129,516.70	170,991.50
113	Хөрөнгийн албан татвар	19,492.10	17,710.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,307.70	36,531.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,444.30	7,423.20
1181	Газрын төлбөр	22,863.40	29,108.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,609.50	2,398.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,609.50	2,398.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,071,466.40	810,572.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,204,175.50	848,839.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,175.50	848,839.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,170.70	820,412.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,652.70	362,559.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,814.10	44,114.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,574.10	297,042.90
2104	Хангамж, бараа материалын зардал	32,960.20	31,299.10
2105	Нормативт зардал	9,142.40	2,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,630.60	30,666.20
2107	Томилолт, зочны зардал	7,448.00	12,228.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,232.90	11,865.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,715.70	28,096.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	621,004.80	28,427.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	47,216.90	189,365.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68,386.60	140,436.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,386.60	140,436.10
2200	Дотоод эх үүсвэрээр	68,386.60	140,436.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(68,386.60)	(140,436.10)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(21,169.70)	48,928.90
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,639.60	111,469.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	111,469.90	160,398.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,056,542.10	987,388.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,421.70	871,011.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,919.70	842,514.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,307.20	362,558.98
210101	Үндсэн цалин	240,087.20	228,997.24
210102	Нэмэгдэл	88,500.00	108,569.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,200.00	13,275.00
210104	Урамшуулал	41,520.00	11,717.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,163.30	44,114.45
210201	Тэтгэврийн даатгал	33,431.10	31,386.73
210202	Тэтгэмжийн даатгал	3,933.10	3,466.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,966.50	1,913.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,966.50	1,372.91
210205	Эрүүл мэндийн даатгал	7,866.10	5,974.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,401.20	297,042.94
210301	Гэрэл, цахилгаан	32,173.00	31,798.54
210302	Түлш, халаалт	259,778.20	260,191.90
210303	Цэвэр, бохир ус	8,450.00	5,052.50
2104	Хангамж, бараа материалын зардал	29,961.50	29,767.30
210401	Бичиг хэрэг	4,905.00	5,016.10
210402	Тээвэр, шатахуун	12,010.00	13,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,400.10	7,171.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,032.90	1,319.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613.50	3,261.00
2105	Нормативт зардал	2,786.20	2,539.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,786.20	2,539.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,832.80	54,726.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000.00	11,442.90
210602	Тавилга	14,549.00	14,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,283.80	1,283.50
210604	Урсгал засвар	28,000.00	27,999.70
2107	Томилолт, зочны зардал	12,262.50	12,228.00
210702	Дотоод албан томилолт	12,262.50	12,228.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,800.00	11,440.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,155.00	8,222.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	454.70	-
210803	Даатгалын үйлчилгээ	325.70	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	994.50	241.01
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	125.80	13.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000.60	2,285.60
210807	Газрын төлбөр	743.70	678.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,405.00	28,096.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,500.00	23,192.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,905.00	4,904.60

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,502.00	28,497.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,502.00	28,497.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502.00	17,502.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,000.00	10,995.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,209.20	116,376.23
223001	Бусад хөрөнгө	120,209.20	116,376.23
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,911.20	-
230001	Эргэж төлөгдөх зээл	20,911.20	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,056,542.10	965,273.79
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,016,615.40	965,273.79
320001	Орон нутгийн төсвөөс	936,821.70	885,480.09
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	79,793.70	79,793.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	39,926.70	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	39,326.70	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	60,208.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	38,093.83

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн нэгж мөн” гэж сумын Засаг даргын эрх зүйн харилцаанд оролцох байдлыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хуульд “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 15.4.-д Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Гурванбаян тосгоны Захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51.1 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	111,469.88	160,398.79	48,928.91
Авлага	39,127.67	41,533.92	2,406.25
Урьдчилгаа	695.77	113,827.50	113,131.73
Бараа материал	82,996.56	94,377.78	11,381.22
Үндсэн хөрөнгө	1,160,915.99	933,956.46	-226,959.53
Нийт хөрөнгө	1,395,205.88	1,344,094.46	(51,111.42)
Өр төлбөр	143.89	143.89	0.00
Засгийн газрын оруулсан капитал	165,881.06	165,881.06	0.00
Хуримтлагдсан үр дүн	1,057,296.74	1,006,185.32	-51,111.42
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,884.18	171,884.18	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,395,205.88	1,344,094.46	(51,111.42)

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 160,398.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 48,928.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	110,667.29	151,856.10	41,188.81
Төрийн сангийн харилцах	110,667.29	151,856.10	41,188.81
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	802.59	8,542.70	7,740.10
Дүн	111,469.88	160,398.79	48,928.91

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 113,762.3 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 17,182.6 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 20,911.2 мянган төгрөг байна. Үүнээс 151,856.1 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд, замд яваа 8,542.7 мянган төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 41,533.9 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	544.17	-	(544.17)
Бусад авлага	2,062.65	5,013.06	2,950.42
Хувь хүмүүст олгосон зээл	36,520.86	36,520.86	-
Дүн	39,127.67	41,533.92	2,406.25

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл 36,520.9 мянган төгрөг, Захирагчийн ажлын албаны татварын байгууллагаас авах авлага 3,070.4 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах хугацаа хэтэрсэн насжилт өндөр авлагын үлдэгдэл 1,942.6 мянган төгрөг байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 113,827.5 мянган төгрөг болж өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилж гарсан зардлын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	82.46	113,214.19	113,131.73
Цалингийн урьдчилгаа	613.31	613.31	-
Дүн	695.77	113,827.50	113,131.73

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардлын үлдэгдэлд Захирагчийн ажлын албаны цалингийн урьдчилгаа 613.3 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын зураг төсвийн урьдчилгаа 1,300.0 мянган төгрөг мөн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй орлогод аваагүй хөрөнгийн 111,831.7 мянган төгрөг байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 94,377.78 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,381.22 мянган төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Түүхий эд материал	17,954.51	19,617.51	1,663.00
Хангамжийн материал	65,042.05	74,760.27	9,718.22
Бичиг хэргийн материал	4,282.48	5,273.98	991.50
Аж ахуйн материал	7,245.79	6,977.52	(268.27)
Түлш, шатах тослох материал	99.56	1,441.00	1,341.44
Бусад хангамжийн материал	35,672.02	36,621.07	949.05
Мал амьтад	-	3,960.00	3,960.00
Дүн	82,996.56	94,377.78	11,381.22

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал данс худалдаж авсан 45,184.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,960.0 мянган төгрөгийн материалаар нэмэгдэж, 37,763.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 933,956.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 226,959.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Биет хөрөнгө	1,138,623.99	911,664.46	(226,959.53)
Барилга, байгууламж, орон сууц	438,435.27	377,141.51	(61,293.77)
Авто-тээврийн хэрэгсэл	57,007.62	40,000.95	(17,006.67)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,803.55	13,799.63	1,996.08
Тавилга, аж ахуйн эд хогшил	20,730.29	26,115.88	5,385.59
Бусад үндсэн хөрөнгө	610,502.26	454,461.49	(156,040.77)
Ном	145.00	145.00	-
Биет бус хөрөнгө	22,292.00	22,292.00	-
Програм хангамж	-	-	-
Бусад биет бус хөрөнгө	22,292.00	22,292.00	-
Дүн	1,160,915.99	933,956.46	(226,959.53)

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс сумын ОНХС-аас үнэ төлбөргүйгээр Захирагчийн ажлын албаны үндсэн хөрөнгөнд орлого авсан усны эх хамгаалах хашаа 20,000.0 мянган төгрөг, худалдан авсан 24,059.9 мянган төгрөгөөр өсч, тээврийн хэрэгсэл данснаас акталсан 4 ширхэг хөрөнгө 74,300.0 мянган төгрөг болон тайлант хугацааны элэгдлийн зардлаар буурсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 7. Өр төлбөрийн үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	-	-	-
Хувь хүмүүсд төлөх өглөг	143.89	143.89	
Дүн	143.89	143.89	-

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд Захирагчийн ажлын албаны хувь хүмүүст өгөх өглөг 143.9 мянган төгрөг байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,343,950.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 51,111.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	165,881.06	165,881.06	0.00
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	165,881.06	165,881.06	0.00
Хуримтлагдсан үр дүн	1,057,296.74	1,006,185.32	-51,111.42
Өмнөх үеийн үр дүн	1,103,222.86	1,057,296.74	-45,926.12
Тайлант үеийн үр дүн	(45,926.12)	(51,111.42)	-5,185.30
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,884.18	171,884.18	0.00
Дүн	1,395,061.98	1,343,950.56	-51,111.42

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны үр дүнгийн бууралт байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 990,915.4 мянган төгрөг байхаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өмнөдэлгэр сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 1,056,542.1 мянган төгрөгөөр баталж, төсөвт тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.2.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Гурванбаян тосгоны төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 685,940.2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 79,793.7 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр ОНХС-ийн санхүүжилтийг бүрэн олгож, санхүүгийн дэмжлэгийг 728,821.7 мянган төгрөгөөр буюу 42,881.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Өмнөдэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гурванбаян тосгоны 2024 оны төсвийг тодотгон батлах тухай 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/13 дугаар тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 182,300.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 228,892.67 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 46,592.67 мянган төгрөгөөр буюу 25.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын төсвийн орлого / мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
	Татварын орлого	178,500.00	225,233.67	126.18	46,733.67
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	100,000.00	150,459.69	150.46	50,459.69
2	Үйл ажиллагааны орлого	2,000.00	1,348.25	67.41	(651.75)
3	Хөрөнгийн орлого	14,000.00	18,543.06	132.45	4,543.06
4	Хөрөнгийн борлуулсны орлого	-	640.50		640.50
5	Бууны албан татвар	500.00	420.00	84.00	(80.00)
6	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,200.00	2,822.37	235.20	1,622.37
7	Улсын тэмдэгтийн хураамж	400.00	5,500.00	1,375.00	5,100.00
8	Малын тоо толгойн албан татвар	22,000.00	14,468.11	65.76	(7,531.89)
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,400.00	1,923.20	56.56	(1,476.80)
10	Газрын төлбөр	35,000.00	29,108.50		(5,891.50)
	Татварын бус орлого	3,800.00	3,659.00	96.29	(141.00)
11	Торгуулийн орлого	3,000.00	2,050.00	68.33	(950.00)
12	Бусад орлого	200.00	348.00		148.00
13	Төсөвт байгууллагын өөрийн орлого	600.00	1,261.00	210.17	661.00
	НИЙТ	182,300.00	228,892.67	125.56	46,592.67

Сумын төсвийн орлогын биелэлтэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгийн орлого, улсын тэмдэгтийн хураамжийн орлого нөлөөлсөн байна. 2023-2024 онд нийт нутгаар өвөлжилт хүндэрч, зудын байдалтай байснаас 2024 оны малын тоо толгойн албан татварыг чөлөөлснөөс орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй 65.8 хувийн биелэлттэй байна.

3.5.2.2 Төсвийн зарлага

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,056,542.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 915,421.7 мянган төгрөгийг урсгал

зардалд, 120,209.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 20,911.2 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 936,821.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 79,793.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 600.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 39,326.7 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 926,937.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 79,793.7 мянган төгрөг, нийт 1,006,731.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ОНХС-д малын тоо толгойн албан татварын 14,468.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 987,388.2 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь урсгал зардлыг 44,409.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 3,833.0 мянган төгрөгөөр, эргэн төлөгдөх зээлийн зардлыг 20,911.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80106 Баг, хорооны ҮАЗардал	581,657.70	540,009.27	41,648.43	92.84
2	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	277,362.00	274,913.50	2,448.50	99.12
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	28,502.00	28,497.00	5.00	99.98
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	13,000.00	12,992.20	7.80	99.94
5	81103 Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө	7,500.00	7,200.00	300.00	96.00
6	81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	20,911.20	-	20,911.20	-
7	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийл	1,000.00	1,000.00	0.00	100.00
8	82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	3,400.00	3,400.00	0.00	100.00
9	82801 Улсын их баяр наадам	3,000.00	3,000.00	0.00	100.00
10	83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	79,793.70	80,100.00	-306.30	100.38
11	83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	22,000.00	15,544.50	6,455.50	70.66
12	83406 ОНХС - Бусад	18,415.50	20,731.73		112.58
	НИЙТ	1,056,542.10	987,388.20	71,470.12	93.45

Эх сурвалж: Гурванбаян тосгоны Захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 43,879.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс Захирагчийн ажлын алба 41,431.2 мянган төгрөг, Соёлын төв 2,351.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв 96,5 мянган төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 0,1 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 141,120.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 4,544.5 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ажлыг гүйцэтгэн Захирагчийн ажлын албанд хүлээлгэн өгч, 111,831.7 мянган төгрөгийн өртөг бүхий 4 ажлыг бүрэн дуусгаж хүлээлцэлгүй ОНХС-ийн тайланд урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Хэрлэнбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангаас нийт зардлын дүн 1,286,686.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 12,866.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,650.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн төвлөрүүлэн захирагч хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгадагч төсвийн шууд захирагчийн байгууллагад хамааралтай 32, төсвийн төвлөрүүлэн захирагчид хамааралтай 2 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Гурванбаян тосгоны Захирагч

1. Орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдэл 24,961.6 мянган төгрөгийг төлөвлөж, батлаагүй байна
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.
2. Шилэн дансны цахим сайт дахь мэдээллийг шалган үзэхэд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг байршуулаагүй, сар бүр мэдээлэх төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг тогтмол хугацаа хоцроосон, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг сүүлийн 3 сар байршуулаагүй.
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гурванбаян тосгоны Захирагч нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээллээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 566.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1,433,560.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелэлтийг хангаж, хугацаанд нь ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	
Албан шаардлага	1.00	566.00	1.00	566.00	100%
Зөвлөмж	1.00	1,433,560.10	1.00	1,433,560.10	100%
Нийт дүн	2.00	1,434,126.10	2.00	1,434,126.10	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 5 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Эрүүл мэндийн төвд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, Ерөнхий боловсролын сургууль болон Хүүхдийн цэцэрлэгт “Стандарт дүгнэлт аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт тус тус өгсөн. Аймаг дахь Төрийн аудитын газар Захирагчийн ажлын алба, Соёлын төв, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санг аудитын түүвэрт хамруулан үе шатны ажлыг хийж гүйцэтгэсэн.

5.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 979,149.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 560,034.3 мянган төгрөгийн 7 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,082.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 417,034.5 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Захирагчийн ажлын алба

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын зураг төсвийн урьдчилгаа төлбөрийг тайлант хугацааны зардалд бүртгэснийг авлагаар тусгаж залруулав
2. Үндсэн хөрөнгийн орлогыг 95.000.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлснийг бууруулж залруулав
3. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 127,085.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн, тайлант хугацааны элэгдлийг зардлыг 70,981.9 мянган төгрөгөөр дутуу тооцсоныг гүйцээж залруулав.
4. Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг 4,887.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залруулав.
5. Албан хаагчдад томилолтын тооцоотой давхардуулан хоолны мөнгө олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

6. 2 албан хаагчид олгосон нэг удаагийн мөнгөн урамшууллаас 1,750.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

7. Цалингийн зардлын хэмнэгдсэн төсвөөс ахмадын сан дансанд 3.933.1 мянган төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

8. Захирагчийн мөрийн хөтөлбөрт тусгаагдаагүй ажилд, гэрээ байгуулалгүйгээр сургалтын төлбөр болох 1,989.6 мянган төгрөгийг олгосон.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

9. Цалингийн зардлыг 1,773.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцоолж тайланд тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Орон нутгийн хөгжлийн сан

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй, гүйцэтгэл дутуу ажлын урьдчилгаа 111,831.7 мянган төлбөрийг тайлант хугацааны зардалд бүртгэснийг урьдчилж гарсан зардал дансанд тусгаж залруулав.
2. Тайлант хугацааны орлогын дүнг 42,829.0 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг бууруулж залруулав.

5.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,807.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17,899.9 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 4,907.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

Соёлын төв

1. Бараа материалын орлогыг 1440.0 мянган төгрөгөөр дутуу тусгаж зардалд бүртгэснийг залруулав.
2. Сарын мэдээний программын 2025 оны төлбөр 180.0 мянган төгрөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэснийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж залруулав.
3. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 5,959.2 мянган төгрөгөөр дутуу тооцон санхүүгийн тайланд тусгасныг нэмэгдүүлж залруулав.
4. Урсгал засварт зарцуулсан 5,214.7 мянган төгрөгийн бараа материалыг үлдээгдлээр тайлагнасныг зардлаар хүлээн зөвшөөрч залруулав.

Ерөнхий боловсролын сургууль

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2221.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг бууруулж залруулав.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг анхан шатны баримтаас 2884.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг бууруулж залруулав.
3. Цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4,907.3 мянган төгрөгийг төлж зардлын эдийн засгийн ангиал зөрүүлэн зарцуулсан, санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 2,884.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2,221.5 төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

5.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Гурванбаян тосгоны Захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 515,457.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 106,119.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 409,338.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

5.3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.3.2 Албан шаардлага

Аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг энэ тайлангийн 4.4-т дэлгэрэнгүй харуулав.

5.3.3 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ЗАА	4.00	299,254.45	-	-	4.00	299,254.45	-	-	-	-	-	-
ОНХС	2.00	154,660.68	-	-	2.00	154,660.68	-	-	-	-	-	-
ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ОН-ын дүн	6	453,915.13	-	-	6	453,915.13	-	-	-	-	-	-
ЕБС	2	5,106.03	-	-	2	5,106.03	-	-	-	-	-	-
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Соёлын төв	4	12,793.87	2	5,394.70	2	7,399.17	-	-	-	-	-	-
ЭМТ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
УТ-ын дүн	6	17,899.91	2	5,394.70	4	12,505.21	-	-	-	-	-	-
Гурванбаян захирагч	1	106,119.14	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТТЗ-ын дүн	1	106,119.14	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	13	577,934.18	2	5,394.70	10	466,420.34	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗАА	4.0	8,026.5	1.0	330.0	3.0	7,696.5	-	-	-	-	-	-
ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ОНБ-ын дүн	4.0	8,026.5	1.0	330.0	3.0	7,696.5	-	-	-	-	-	-
ЕБС	1.0	4,907.3	-	-	1.0	4,907.3	-	-	-	-	-	-
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭМТ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
УТБ-ын дүн	1.0	4,907.3	-	-	1.0	4,907.3	-	-	-	-	-	-
Гурванбаян захирагч	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТТЗ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	5.0	12,933.8	1.0	330.0	4.0	12,603.8	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗАА	1	1,750.2	1	1,750.2	-	-	-	-	-	-	-	-
ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ХХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ОНБ-ын дүн	1	1,750	1	1,750	-	-	-	-	-	-	-	-
ЕБС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭМТ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
УТБ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гурванбаян захирагч	2	409,338.0	-	-	2	409,338.0	-	-	-	-	-	-
ТТЗ-ын дүн	2	409,338.0	-	-	2	409,338.0	-	-	-	-	-	-
Нийт дүн	3	411,088.2	1.0	1,750.2	2	409,338.0	-	-	-	-	-	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 25

Дугаар 172-ХЭА-2025/011/НА-СТА-ТТЗ
А2371281
Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдэл 24,961.6 мянган төгрөгийг бүрэн төлөвлөж батлаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2. "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3. "Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4. "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны Захирагч Ж.Энххуяг, санхүүгийн албаны дарга Б.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 25

Дугаар 171-ХЭА-2025/011/НА-СТА-ТТЗ
А 237 1281 Чингис хот

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим сайтад 384,376.4 мянган төгрөгийн мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 7 дугаар зүйлийн 7.1. "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.1. "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны Захирагч Ж.Энххуяг, санхүүгийн албаны дарга Б.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР

